



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН
ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ



RioTinto

СУДАЛГААНЫ ТЭТГЭЛЭГ

СУДАЛГААНЫ
ТЭТГЭЛГИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ
УДИРДАМЖ

2022 он



УУЛ УУРХАЙН СУДАЛГААНЫ ТЭТГЭЛЭГ

УУЛ УУРХАЙН СУДАЛГААНЫ ТЭТГЭЛГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДАМЖ

ШУТИС болон “Оюу толгой” ХХК, “Рио Тинто Монгол” ХХК хоорондын “Уул уурхайн геотехник мэргэжлээр инженер бэлтгэх, олон улсын судалгааны төв байгуулах” хамтын ажиллагааны гэрээний хүрээнд хэрэгжүүлэх “Судалгааны тэтгэлэг” олгоход энэхүү удирдамжийг дагаж мөрдөнө.

“Уул уурхайн геотехник мэргэжлээр инженер бэлтгэх, олон улсын судалгааны төв байгуулах” төслийн Удирдах хороо батлав.

НЭГ. СУДАЛГААНЫ ТЭТГЭЛГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО

- 1.1 **Судалгааны тэтгэлгийг хэрэгжүүлэх үндэслэл:** Монгол улсын эдийн засгийн тэргүүлэх салбар болох уул уурхайн салбарт хэрэгцээтэй байгаа инженерүүдийг бэлтгэх, уул уурхайн үйлдвэрлэлд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, геологи, уул уурхайн салбарын судалгаа шинжилгээг хөгжүүлэх зорилгоор 2019 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн “Оюу Толгой” ХХК болон ШУТИС-ийн ГУУС-ийн хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичиг, 2021 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн ШУТИС, “Оюу толгой” ХХК болон “Рио Тинто Монгол” ХХК-ний хоорондын “Уул уурхайн геотехник мэргэжлээр инженер бэлтгэх, олон улсын судалгааны төв байгуулах” хамтын ажиллагааны гэрээний хүрээнд “Судалгааны тэтгэлэгт хөтөлбөр”-ийг 2021-2025 онд хэрэгжүүлнэ.
- 1.2 **Зорилго:** Уулын үйлдвэрлэлийн бүтээмж, тогтвортой байдал, аюулгүй ажиллагааг дээшлүүлэхэд ШУТИС, “Оюу Толгой” ХХК болон “Рио Тинто Монгол” ХХК хамтарч гүний уурхайд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэгдсэн судалгааны ажлыг дэмжин шинэ мэдлэгийг бий болгох үйл ажиллагааг санхүүжүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино. Энэхүү зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 1.2.1 “Оюу толгой” ХХК болон “Рио Тинто Монгол” ХХК-ийн уурхайд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, шинэ техник технологи нэвтрүүлэх;
 - 1.2.2 ШУТИС-ийн судалгаа хөгжүүлэлтэд зориулсан санхүүжилтийг нэмэгдүүлэх, үр дүнтэй судалгаа хийх чадавхыг бүрдүүлэх;
 - 1.2.3 ШУТИС, “Оюу толгой” ХХК, “Рио Тинто Монгол” ХХК болон гадаадын их, дээд сургууль, бусад оролцогч талуудын эрдэмтэн судлаачдын судалгаа хөгжүүлэлтийн хамтын ажиллагааг дэмжих;
 - 1.2.4 Монгол улсын уул уурхайн салбарт хувь нэмэр оруулах салбар дундын судалгааг хөгжүүлэх.

ХОЁР. ХАМРАГДАХ ХҮРЭЭ

- 2.1 ШУТИС-ийн багш, судлаач, ахисан түвшний оюутнууд болон тэдэнтэй хамтран судалгааны ажил гүйцэтгэх “Оюу толгой” ХХК, “Рио Тинто Монгол” ХХК, бусад инженер, техникийн ажилтнууд, Гадаад, дотоодын их дээд сургуулийн профессор, эрдэм шинжилгээний байгууллагын эрдэмтэн судлаачид, бусад сонирхогч талуудад хамаарна.
- 2.2 Судалгааны тэтгэлэгт хөтөлбөр /цаашид “СТХ” гэх/-т төсөл мэдүүлэх судалгааны багийн удирдагч нь ШУТИС-ийн үндсэн орон тооны доктор буюу түүнээс дээш эрдмийн зэрэг цолтой профессор, багш, судлаач байна. Судалгааны багаа энэхүү удирдамжийн 2.1-т заасан талуудаас бүрдүүлнэ.

ГУРАВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Энэ удирдамжид хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.

- 3.1 **Судалгааны тэтгэлэг:** Судалгааны төслийг санхүүжүүлэх зорилгоор “Оюу толгой” ХХК, “Рио Тинто Монгол” ХХК болон бусад талуудаас олгох хөрөнгийг;
- 3.2 **Удирдах хороо:** Тэтгэлэгт хөтөлбөрийг удирдлагаар хангах чиг үүрэг бүхий “Уул уурхайн геотехник мэргэжлээр инженер бэлтгэх, олон улсын судалгааны төв байгуулах” төслийн Удирдах хороог;
- 3.3 **СТХ-ийн ажлын хэсэг:** Судалгааны төслийн саналуудад удирдамжийн дагуу хянан магадалгаа хийн, шинжээчдийн багаар дүгнэлт гаргуулж, тэтгэлэг олгох эсэх,

- шалгарсан төслийн явцын болон эцсийн үр дүнг хүлээн авах эсэх саналыг Удирдах хороонд хүргүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг;
- 3.4 **Шинжээчдийн баг:** Сонгон шалгаруулах үйл ажиллагааны хүрээнд төслийн агуулгыг хянаж, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий мэргэжлийн шинжээчдээс бүрдсэн багийг;
- 3.5 **Эрдмийн зөвлөл:** Төслийн явцын болон эцсийн үр дүнг хянах, хэлэлцэх, санал, зөвлөмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ШУТИС-ийн дүрмийн 4.6-т заасан зөвлөлийг;
- 3.6 **ШУТИС-ийн Ажлын хэсэг:** ШУТИС-ийн захирлын тушаалаар байгуулагдсан, “Уул уурхайн геотехник мэргэжлээр инженер бэлтгэх, олон улсын судалгааны төв байгуулах” хамтын ажиллагааны гэрээг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг;
- 3.7 **Гадаад хамтын ажиллагаа (ГХА) ба СТХ-ийн ажлын дэд хэсэг:** Судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулан хянах үүрэгтэй ажлын дэд хэсгийг;
- 3.8 **ГХА ба СТХ-ийн Нарийн бичиг:** СТХ-ийн Нарийн бичгийн үүргийг давхар гүйцэтгэх бөгөөд судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны зохион байгуулалтыг хариуцан ажиллах мэргэжилтнийг;
- 3.9 **Судалгааны тэтгэлгийн төсөв:** Тухайн онд батлагдсан санхүүжилтийн дүнг;
- 3.10 **Судалгааны төсөл:** Судалгааны багийн зорилго, гарах үр дүн, хүлээлт нь тодорхой даалгаварт судалгааны ажлыг;

ДӨРӨВ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 4.1 **Удирдах хороо нь** судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдах, тэтгэлэг олгох эсэх шийдвэр гаргах, төсөв зардал батлах, СТХ-ийн Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлах, явцын болон эцсийн үр дүнг хүлээн авна.
- 4.2 **СТХ-ийн ажлын хэсэг нь** судалгааны төслүүдийг сонгон шалгаруулах, шалгарсан төслүүдийн явцын болон эцсийн үр дүнг хүлээн авах үйл ажиллагааг зохион байгуулна. ШУТИС, “Оюу Толгой” ХХК болон “Рио Тинто Монгол” ХХК-ийн төлөөллөөс бүрдсэн 7 гишүүнтэй байна. Ажлын хэсэгт “Оюу Толгой” ХХК болон “Рио Тинто Монгол” ХХК тус бүрээс хоёр, ШУТИС-ээс гурван төлөөлөл байна.
- 4.3 **Шинжээчдийн багийг** 5.1-т заасан судалгааны чиглэл тус бүрээр ШУТИС-ийн Ажлын хэсэг, “Оюу Толгой” ХХК болон “Рио Тинто Монгол” ХХК-ийн саналыг харгалзан, ГХА ба СТХ-ийн ажлын хэсэг нэр дэвшүүлж, ШУТИС-ийн ГУУС-ийн захирал хүн тус бүртэй гэрээ байгуулна.
- 4.4 **Шинжээчдийн багийн гишүүн нь** доктор ба түүнээс дээш эрдмийн зэрэг, цолтой эсвэл зөвлөх, мэргэшсэн зэрэгтэй эрдэмтэн судлаачид байна.
- 4.5 **Эрдмийн зөвлөл нь:** ШУТИС-ийн захирлын 2022 оны 4-р сарын 29-ны өдрийн А/145 тоот тушаалаар баталсан “ШУТИС-д төсөл, гэрээт ажил хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээний үйл ажиллагааг санхүүжүүлэх” журмын 8.4.5-д заасны дагуу Төслийн явц, эцсийн үр дүнг бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн эрдмийн зөвлөлөөр хагас жил тутам хэлэлцүүлж, шалгах хуудсаар дүгнэнэ.
- 4.6 **Судалгааны ажлын явцын болон эцсийн үр дүнг** төслийн голлох салбарыг (төслийн агуулгын 50%-с дээш) хамаарах сургуулийн Эрдмийн зөвлөл хянан, хэлэлцэж, санал, зөвлөмж, дүгнэлт гаргана. Шаардлагатай тохиолдолд санхүүжүүлэгч, захиалагч талын болон бусад салбарын төлөөллүүдийг хамруулан өргөтгөсөн хэлбэрээр зохион байгуулна.
- 4.7 **СТХ-ийн Нарийн бичиг нь** ГХА ба СТХ-ийн дэд ажлын хэсгийн нарийн бичиг байх бөгөөд ШУТИС-ийн ГУУС-ийн захиралтай тусгайлан гэрээ байгуулах ба тухайн гэрээнд заагдсан ажил үүргийг гүйцэтгэнэ.

ТАВ. ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАХ

5.1 Судалгааны төсөл нь дараах үндсэн чиглэлүүдийг хамарсан байна. Үүнд:

- 5.1.1 Ашиглалтын талбайн дагуух улаар огтлох түвшинд (undercut) малталтуудыг нэвтрэх үед үлдэх уулын цулын даралтын хүчдэлийг бууруулах ба энэ нь олборлолтын түвшин дэх хүрээний (тойрсон) малталтуудад хэрхэн нөлөөлөх (үйлчлэх) байдлыг үнэлэх. Үүнд ашиглалтын талбайн хамгийн бага эрсдэлтэй хэсгүүдийг тогтоох, мөн түүнчлэн улаар огтлох түвшний малталтуудыг эргэн тойронд үлдээх уулын цулд перпендикуляр нэвтрэх үеийн хамгаалалтын цулын хэсгүүд доор (ба/эсвэл аль нэг байрлалд) хүчдэл хэмжигч мэдрэгчүүдийг суурилуулах.
- 5.1.2 Хэсэг хүдэр юүлүүрүүдийн дээр болон эргэн тойронд geo4site маркер (эсвэл network smart markers) суурилуулан тэдгээрийн хэлбэр, хэмжээ ба юүлүүрт буух хүдрийн хэмжээ ихсэх хурдыг тооцож тогтоох ба хүдэр юүлүүрүүд хоорондын ба хүдэр буулгах цэгүүд хоорондын харилцан үйлчлэлийг илрүүлэн хяналт хийх. (Энэхүү туршилт өмнө нь өөр далд уурхайнуудад хийгдсэн жишээ байдаг боловч Оюутолгойн далд уурхайн хувьд огт хийгдээгүй болно.)
- 5.1.3 Хүдэр буулгах цэгүүдийн эгц урд (нүүрэн хэсэгт) овор хэтэрсэн чулуулаг олборлолтын малталт руу орохоос урьдчилан хамгаалах хананы (өндөр) нөлөөллийг (үйлчлэл) шалгах. (Колорадо-ын чулуулаг уналтын программ хангамаар хийгдсэн загварчлалын хуучин симуляци хийгдсэн боловч, түүнээс хойш нэмэгдсэн болон хэвлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээл байхгүй.)
- 5.1.4 Хүдэр буулгах цэгүүд дэх хүдэр ба чулуулгийн төрлүүдийг, мөн түүнчлэн мөхлөгийн (ширхэглэлийн) хэмжээг судалж тогтоох аргачлал бүхий геологийн болон бутлагдлын зэрэглэлийн мониторингийн хөтөлбөрийг үр ашигтай байдлаар хэрэгжүүлэх. (Үүнд зөвлөмж байдлаар: ухаж ачих машинд камер/сканнер, дрон аль эсвэл алсын удирдлагат дугуйт робот техник ашиглах.)
- 5.1.5 Уул уурхайн геотехниктэй холбоотой бусад чиглэлүүд.

5.2 Судалгааны төсөлд тавигдах шаардлага:

- 5.2.1. Судалгааны багт дэд удирдагч буюу гадаадын их дээд сургуулийн профессор, эрдэм шинжилгээний байгууллагын эрдэмтэн судлаач нэг, ШУТИС-ийн үндсэн болон гэрээт профессор багш, судлаач, ажилтан 2-с дээш, ахисан түвшний (магистр, доктор) 1-с дээш оюутныг заавал оролцуулна;
- 5.2.2. Судалгааны багийн дэд удирдагч буюу гадаадын их дээд сургуулийн профессор, эрдэм шинжилгээний байгууллагын эрдэмтэн судлаач нь төсөл хэрэгжих хугацаанд нэгээс доошгүй удаа ШУТИС-д зочин профессороор ирж ажиллана;
- 5.2.3. Судалгааны багийн удирдагч нэг, судалгааны багийн гишүүн нь СТХ-ийн хоёроос дээш төсөлд оролцохгүй;
- 5.2.4. Судалгааны багийн удирдагч, гишүүд өмнө нь СТХ-т хамрагдсан төслийн гэрээний эрх үүргийн зөрчилгүй байх;
- 5.2.5. Дэвшүүлж буй судалгааны төсөл нь зарлагдсан чиглэлийн дагуу, шийдвэрлэх асуудал тодорхой, ач холбогдолтой, оновчтой судалгааны арга замыг сонгосон байх;
- 5.2.6. Төслийн үр дүнд оюуны өмчийн эрхийн баталгаажуулалт авах боломжтой байвал давуу тал болно;
- 5.2.7. Судалгааны төслийн үр дүнг эзэмших, ашиглахыг захиалагч/санхүүжүүлэгч, гүйцэтгэгч байгууллагад зөвшөөрөх;

- 5.2.8. Төслөөр хүсэж буй санхүүжилтийн дээд хэмжээ нь **100,000 ам.доллар** түүнтэй тэнцэх төгрөг байна;
- 5.2.9. Судалгааны төслийг хэрэгжүүлэх хугацаа **24 сараас** хэтрэхгүй байх;
- 5.2.10. Төсөл мэдүүлэхдээ удирдамжийн 1-р хавсралтад заасан **Төсөл Мэдүүлэх Заавар, Маягт №1-ын** дагуу мэдүүлнэ (Материал дутуу ирүүлсэн тохиолдолд сонгон шалгаруулалтад оролцох боломжгүй).

5.3 Төсөл дэвшүүлэх багийн гишүүдэд тавигдах шаардлага:

5.3.1. Судалгааны багт тавигдах шаардлага:

- Судалгааны багийн гишүүдийн тоог хязгаарлахгүй бөгөөд багийн гишүүд нь гадаад, дотоодын их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын багш, эрдэмтэн, судлаач, ажилтан, ахисан түвшний оюутан болон салбарын инженер, техникийн ажилтан байна.
- Багт дараах гишүүдийг заавал хамруулсан байна.
 - Гадаадын их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын үндсэн орон тооны профессоргыг дэд удирдагчаар ажиллуулах;
 - Судалгааны багийн удирдагчаас гадна ШУТИС-ийн үндсэн болон гэрээт 2-с дээш багш, ажилтан оролцуулсан байх;
 - ШУТИС-ийн ахисан түвшний (магистр, доктор) 1-с дээш оюутныг оролцуулсан байх.

5.3.2. Судалгааны багийн удирдагч:

- ШУТИС-ийн үндсэн орон тооны профессор, багш, судлаач байх;
- Доктор буюу түүнээс дээш эрдмийн зэрэг цолтой байх;
- Судалгааны багийн удирдагчаар ажиллаж байсан туршлагатай байх;
- Тухайн судалгааны чиглэлээр мэргэшсэн, зөвлөх зэрэгтэй бол давуу тал болно;
- Англи хэл дээр тайлан боловсруулах, илтгэл хэлэлцүүлэх чадвартай байх.

5.3.3. Дэд удирдагч:

- Гадаадын их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын үндсэн ажилтан байх;
- Доктор буюу түүнээс дээш эрдмийн зэрэг цолтой байх;
- Дэд удирдагчийн харьяалагдах байгууллага нь ШУТИС-тай хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээ байгуулсан байх;
- Дэвшүүлж буй төслийн чиглэлээр олон улсын мэдээллийн санд бүртгэлтэй (Web of Science болон Scopus) сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэн байх;
- Судалгааны багийн удирдагчид дэмжлэг үзүүлэн дэд удирдагчаар ажиллаж, төсөл хэрэгжих хугацаанд нэгээс доошгүй удаа ШУТИС-д зочин профессороор ирж ажиллахыг зөвшөөрсөн байх.

5.4 Төсөл мэдүүлэхэд бүрдүүлэх материал:

- Судалгааны баг нь доорх материалыг бүрдүүлэн, хүсэлтээ СТХ-ийн нарийн бичгийн research@must.edu.mn хаягт цахимаар хүргүүлнэ.
 - Судалгааны багийн удирдагчийн харьяалагдах бүрэлдэхүүн сургууль, нэгжийн удирдлагын гарын үсэг бүхий төслийг дэмжсэн албан бичиг;
 - Төсөл мэдүүлэх заавар, маягт /Хавсралт №1/-ын дагуу бөглөж баталгаажуулсан ТӨСЛИЙН САНАЛ;

5.5 Төслийн материал хүлээн авах хугацаа:

Төслийн материалыг 2022 оны **10 дугаар сарын 28-ны** өдрийг дуустал хүлээн авна.

5.6 Судалгааны төслийг сонгон шалгаруулах үйл явц: Судалгааны төслийг 2022 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн дотор дараах 4 үе шаттайгаар сонгон шалгаруулна /Хавсралт №2/.

- Үе шат 1. Судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийг зарлах;
- Үе шат 2. Өргөдөл авах эцсийн хугацаа, СТХ-ийн нарийн бичгийн дарга өргөдлийг хүлээн авах
- Үе шат 3. Үнэлэх үйл явц
- Үе шат 4. Удирдах хорооны шийдвэр, шалгарсан төслийн багийг зарлах

ЗУРГАА. ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ

6.1 Судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийн санхүүжилтийг зөвхөн судалгаа хийхтэй холбоотой дараах зардлуудад зарцуулах бөгөөд эдгээр зардлаар хязгаарлагдахгүй.

- 6.1.1 Дотоодын Судалгааны багийн гишүүдийн ажлын хөлс;
- 6.1.2 Лабораторийн туршилт хийхтэй холбоотой зардлууд;
- 6.1.3 Судалгаатай холбоотой технологийн лиценз худалдан авахтай холбоотой зардал;
- 6.1.4 Орон нутагт судалгаа хийхтэй холбоотой зардал;
- 6.1.5 Судалгаатай холбоотой илтгэл тавих эрдэм шинжилгээний хуралд оролцох зардал;
- 6.1.6 Судалгааны ажлын үр дүнг олон улсын мэргэжлийн сэтгүүл болон хуралд хэвлүүлэх зардал (импакт фактор бүхий олон улсын сэтгүүл болон оюуны өмчийн хамгаалалттай холбоотой зардал);
- 6.1.7 ШУТИС-ийн дэд бүтэц, материаллаг баазыг ашигласны шимтгэл хураамж (10%);
- 6.1.8 Судалгааны ажлын явцын болон эцсийн үр дүнг хянах, хэлэлцүүлэх, хүлээн авахтай холбоотой бүх төрлийн зардал;
- 6.1.9 Төслийн Зочин судлаачийг ШУТИС-д ажиллуулахтай холбоотой бүх төрлийн зардал.

6.2 Төслийн санхүүжилтийг эрдмийн зөвлөлөөр улирал тутам болон хагас жил тутамд баталгаажсан судалгааны багийн ажлын тайланд үндэслэн олгоно. судалгааны багийн ажлын үр дүнгийн тайланг ГХА ба СТХ-ийн ажлын дэд хэсгээр улирал тутамд, Эрдмийн зөвлөлөөр хагас жил тутамд баталгаажсан тайланд үндэслэн олгоно.

6.3 Судалгааны баг нь 6.1.9 заалтад тусгагдсан зардлыг бүрэн хариуцна.

6.4 Төслийн эхлэх ба дуусах хугацаа

- Төслийн эхлэх өдөр 2023 оны 1-р сарын 1-нээс эхлэн 24 сарын хугацаатай үргэлжилнэ.
- Гэрээнд заасан хугацаанд төслийн ажлын эцсийн тайланг өгөөгүй тохиолдолд, үлдэгдэл санхүүжилтийг олгохгүй.

6.5 Төслийн хугацаа, болон төсөвт өөрчлөлт оруулах тохиолдолд, гэрээнд заасны дагуу шийдвэрлэнэ.

ДОЛОО. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ТАЙЛАГНАХ

7.1 Төслийн гэрээ байгуулах, баталгаажуулах

7.1.1. ШУТИС, “Оюу Толгой” ХХК, “Рио Тинто Монгол” ХХК болон бусад санхүүжүүлэгч тал, Судалгааны багийн удирдагч нар хамтарсан гэрээ байгуулна;

7.1.2. Судалгааны баг нь судалгааны төслийг хэрэгжүүлэхдээ “ШУТИС-д төсөл, гэрээт ажил хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээний үйл ажиллагааг санхүүжүүлэх” журмыг мөрдөнө.

7.2 Төслийг хэрэгжүүлэх, хяналт тавих

- 7.2.1. Судалгааны багийн удирдагч нь төслийн ажлын даалгавар, түүнийг хийж гүйцэтгэх календарчилсан төлөвлөгөө, төсвийн талаар судалгааны голлох чиглэлд хамаарах ШУТИС-ийн мэргэжлийн эрдмийн зөвлөлд албан ёсоор танилцуулж, судалгааны арга зүйгээ батлуулна;
- 7.2.2. Судалгааны багийн удирдагчийн харьяалагдах сургуулийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга /ЭНБД/ нь шинээр эхэлж буй төслийн мэдээллийг “Эрдэм шинжилгээний мэдээллийн нэгдсэн систем”-д төслийн гэрээ батлагдсанаас хойш 1 сарын дотор бүртгэж, явцын болон эцсийн үр дүнгийн хяналтыг хариуцаж ажиллана.
- 7.2.3. Төслийн арга зүйн түвшин, хэрэгжилтийн явц, хугацаа, үр дүн, санхүүгийн үйл ажиллагааг санхүүжүүлэгч, хэрэгжүүлэгч талуудын төлөөллөөс бүрдсэн ГХА ба СТХ-ийн ажлын дэд хэсгээр улирал тутам, судалгааны голлох чиглэлд хамаарах ШУТИС-ийн мэргэжлийн Эрдмийн зөвлөлөөр хагас жил тутам хэлэлцүүлж, хяналт тавина.
- 7.2.4. Судалгааны багийн удирдагч нь тухайн төслийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн мэдээллийг хагас жил тутам (6, 12 дугаар сар) “Эрдэм шинжилгээний мэдээллийн нэгдсэн систем”-д оруулах бөгөөд ЭНБД нар хянаж, эрдмийн зөвлөлийн дүгнэлтийг хавсарган баталгаажуулна.
- 7.2.5. ГХА ба СТХ-ийн ажлын дэд хэсэг нь хэрэгжиж буй төслүүдийн тайлан дүн мэдээг нэгтгэж, гэрээний эрх үүрэг зөрчигдсөн хэрэгжилт хангалтгүй байгаа төслийг удирдах хороогоор хэлэлцүүлж, шаардлагатай шийдвэрийг гаргуулна.

7.3 Төсөл хэрэгжүүлэгчийн эрх үүрэг

- 7.3.1 Судалгааны баг нь гэрээнд тусгагдсан үр дүнгийн даалгавар, судалгааны төсөлтэй холбоотой үйл ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэх үүрэгтэй.
- 7.3.2 Судалгааны баг нь гэрээнд заасан үр дүнгийн даалгаврын биелэлт, санхүүжилтийн тайлан тооцоог Эрдмийн зөвлөлийн дүгнэлтийн хамт санхүүжүүлэгчид хагас жил тутамд хүргүүлж тайлагнан, дараагийн шатны санхүүжилтээ авна.
- 7.3.3 Судалгааны баг нь гэрээнд заасан графикийн дагуу санхүүжилтээ авч, судалгааны ажлаа хэрэгжүүлнэ.
- 7.3.4 Шаардлагатай тохиолдолд төсөл хэрэгжүүлэгч баг нь төслийн явц, үр дүнг санхүүжүүлэгчийн заасан хугацаанд тайлагнах үүрэгтэй.
- 7.3.5 Төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, зохион байгуулалт, багийн гишүүдийн ажил үүргийн хуваарилалтыг Судалгааны багийн удирдагч, дэд удирдагч нар хамтран шийдвэрлэнэ.
- 7.3.6 Судалгааны багийн удирдагч нь судалгааны багийн нэрийн өмнөөс санхүүжүүлэгч, хэрэгжүүлэгч байгууллагатай гэрээ байгуулж, төслийг амжилттай хэрэгжүүлэх үүргийг хүлээж төслийн эрдэм шинжилгээний болон менежментийг удирдан чиглүүлэх үүрэгтэй.
- 7.3.7 Судалгааны багийн удирдагч нь Судалгааны багийг төлөөлж төслийн бүх асуудлаар санхүүжүүлэгч, хэрэгжүүлэгч байгууллагатай харилцана. Харин дэд удирдагчийн хамтаар судалгааны төслийн үр дүн, тайланг хариуцна.
- 7.3.8 Судалгааны багийн дэд удирдагч нь төслийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг удирдан чиглүүлэх үүрэгтэй. Судалгааны багийг төлөөлж санхүүжүүлэгч, хэрэгжүүлэгч байгууллагатай харилцахгүй, гэхдээ Судалгааны багийн удирдагчийн хамтаар судалгааны төслийн үр дүн, тайланг хариуцна.
- 7.3.9 Судалгааны багийн дэд удирдагчийн харьяалагдах байгууллагаас 5.2.8-д заасан төсөв дээр нэмэлтээр санхүүжилт олгосон тохиолдолд зардлын

хуваарилалт, захиран зарцуулалтыг Судалгааны багийн удирдагч, дэд удирдагч нар хамтран шийдвэрлэнэ.

7.4 Төслийн эцсийн үр дүнг тайлагнах, төслийг хаах

- 7.4.1. Судалгааны багийн удирдагч нь төслийн судалгаа, үйл ажиллагаа бүрэн дуусаж, цаашаа аливаа нэг дутуу ажил үлдээгүй, төлбөр тооцоо дууссан гэдгийг мэдэгдэж, эцсийн тайланг явуулна. Төслийн эцсийн тайланд төслөөс хүлээж байсан эцсийн үр дүнгийн биелэлтийн талаар тусгана.
- 7.4.2. Судалгааны төслийн эцсийн үр дүн, үйл ажиллагааны тайланг “Оюу толгой” ХХК, “Рио Тинто Монгол” ХХК байгууллагуудын төлөөллийг хамруулан ШУТИС-ийн мэргэжлийн эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж, дүгнэлт гаргана.
- 7.4.3. 7.4.2-т дурдсан хурлын дүгнэлт болон ШУТИС-ийн Санхүү, нягтлан бодох бүртгэлийн албанаас баталгаажуулсан санхүүгийн тайланг үндэслэн ШУТИС-ийн Ажлын хэсэг төслийн үр дүнг хүлээлгэн өгөх албан бичгийг Удирдах хороонд хүргүүлнэ.
- 7.4.4. Удирдах хорооны шийдвэрийг үндэслэн талууд төсөл бүрэн дуусаж, төлбөр тооцоо дууссан гэдгийг баталгаажуулж, эцсийн тайланг акт үйлдсэнээр төслийн ажил дуусгавар болно.
- 7.4.5. Судалгааны баг нь гэрээний хугацаа дуусгавар болохоос өмнө төслийн үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэлийн тайланг санхүүжүүлэгч талд актаар хүлээлгэж өгнө. Тус актын нэг хувийг ШУТИС-ийн ажлын хэсэгт ирүүлснээр эцсийн тайланг хүлээлгэн өгөх үйл явц дуусгавар болно.
- 7.4.6. Төслийн хаалт нь “Уул уурхайн геотехник мэргэжлээр инженер бэлтгэх, олон улсын судалгааны төв байгуулах” хамтын ажиллагааны гэрээний талууд уг судалгааны төслийн үр дүнг хүлээн авч, бүх төлбөр тооцоо дууссаныг батална. Санхүүжилтийн эцсийн зарцуулалт нь гэрээгээр зөвшөөрөгдсөн төсөвт үндэслэгдэнэ.
- 7.4.7. Мэдээллийн хадгалалт: Дуусгавар болсон төслийн үр дүн, мэдээллийг ГХА ба СТХ-ийн ажлын дэд хэсэг хариуцан “Эрдэм шинжилгээний мэдээллийн нэгдсэн систем”-д бүртгүүлж, цахим архив үүсгэнэ.

7.5 Төслийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, төслийн хяналттай холбоотой асуудлыг энэхүү удирдамжийн **Хавсралт №2 (Төсөл сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих)** болон төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан удирдамжид тусгагдаагүй асуудлыг судалгааны тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээгээр зохицуулна.

НАЙМ. БУСАД ЗҮЙЛ

- 8.1 Энэхүү удирдамжид нэмэлт өөрчлөлт оруулах эсэхийг талуудын саналыг үндэслэн төслийн Удирдах хорооны хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэнэ.
- 8.2 Төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой үүссэн зөрчил, маргааныг Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

